

“ӨНДӨРХААН” ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 14-ний өдөр

№25/02

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 09:00 цагт танхимаар хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, холбоотой бусад баримт бичгийг бэлэн болгож 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг
Хурал байгуулах комиссын гишүүд:
Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч Ц.Тайшир
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга:
Ө.Бямбагэрэл Ард Секюритиз ҮЦК ХХК
Тооллогын комиссын гишүүн:
Ч.Даваацэрэн Ард Секюритиз ҮЦК ХХК
А.Эрхбилгүүн Ард Секюритиз ҮЦК ХХК
10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ДАРГА  Ч.ГАНХУЯГ



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 03 сарын 17-ны өдрийн
25.122 тоот тогтоолын 1-р хавсралт

“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
5. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай;
7. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай;
8. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай;
9. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай;
10. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай;
11. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.



САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 04 сарын 25-ны өдрийн 09:00 цагт хуралдах “Өндөрхаан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.			
2	ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай.			
3	Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай.			
4	Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай.			
5	Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай.			
6	Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай.			

7	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орсон төслийг батлах.			
---	--	--	--	--

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Ард Секюритиз Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



Төлөөлөгч Удирдах Зөвлөлийн
2025 оны 04 сарын 17-ны өдрийн
тоот тогтоолын 3-р хавсралт

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Өндөрхаан” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зарласан тул эрхэм хувьцаа эзэмшигч та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг хүсэж байна.

ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ГАЗАР: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхарт.

ХУГАЦАА: 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 09:00 цагт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ОНООСОН НЭР: “ӨНДӨРХААН” ХК

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
5. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай;
7. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай;
8. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай;
9. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай;
10. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай;
11. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл, хавсралт;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал;


Хувьцаа эзэмшигч та ажлын өдрүүдэд 9:00–18:00 цагийн хооронд дараах мэдээллийн дагуу холбогдон хурлын материал, саналын хуудастай танилцаж, урьдчилан саналаа өгөх боломжтой.

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Таур, 17 давхарт.
- Имэйл хаяг: info@ardsecurities.com
- Утас: 77003322
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол “Ард Секюритиз” ҮЦК ХХК-д очиж саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх эсхүл Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Таур, 17 давхар хаягаар Өндөрхаан ХК-д саналын хуудсыг шуудангаар явуулах боломжтой. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 18:00 цаг байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

(хурал үргэлжлэх хугацаа 3 цаг бөгөөд 09:00 цагт эхэлж 12:00 цагт дуусна)

№	Хурлын дэг	Хариуцах этгээд	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/;	Тооллогын комисс	09:00-09:15
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/;		
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;	Хурлын дарга	09:15-09:35
4	<ol style="list-style-type: none"> 1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах; 2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах; 3. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах; 4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах; 5. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай; 6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай; 7. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай; 8. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай; 9. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай; 10. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай; 11. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах. 	Хурлын дарга	09:35-11:00
5	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт;	Тооллогын комисс	11:00-11:30
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах;		11:30-11:45
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах;	Хурлын дарга	11:45-11:55
8	Хурлыг хаах.		12:00



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ /ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ /ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ
ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ/ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 (Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 2,127,676 (Хоёр сая нэг зуун хорин долоон зургаан зуун далан зургаа) ширхэг байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Компанийн зарласан энгийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ /ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХООР ШИЙДВЭРЛЭЖ,
ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ЭНГИЙН ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 12,407 (*Арван хоёр мянга дөрвөн зуун долоон төгрөг*) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 (*Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо*) ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан холбогдох гэрээний заалтын дагуу 25,009,993,379 (*хорин таван тэрбум есэн сая ерэн гурван мянга гурван зуун далан ес*) төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, Компанийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх төслийг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ /ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10, 62.1.11 дэх заалт, 2025 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Өндөрхаан ХК-ийн өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах гэж буйтай холбогдуулан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлийн дагуу сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний гэрээ, хэлцэл байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан холбогдох гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд, Санхүү бүртгэл, тайлагнал, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Нягтлан бодогчид тус тус даалгасугай.


ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ТӨСӨЛ

Өндөрхаан ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн
..... дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тогтоолын Хавсралт 1

Хийгдэх гэрээ	Гэрээний үнэ	Оролцогч тал
Хувьцаа худалдах худалдан авах гэрээ, Өрийг хувьцаагаар солих гэрээ	25,009,993,379 (хорин таван тэрбум есэн сая ерэн гурван мянга гурван зуун далан ес) төгрөг	Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Өндөрхаан ХК



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ /ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХТОЙ ХОЛБОГДУУЛАН ХААЛТТАЙ
ХҮРЭЭНД НЭМЖ ГАРГАЖ БУЙ ЭНГИЙН ХУВЬЦААНААС ТЭРГҮҮН ЭЭЛЖИД
ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, 2025 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компаниас нэмж гаргах 2,015,797 (Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо) ширхэг энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д заасан Компанийн нийт зарласан хувьцаанаас хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-д эзэмшүүлэх нөхцөлийг тогтоох, эдгээртэй холбоотой бусад шийдвэрийг тухай бүр гаргах, энэхүү тогтоолыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Тэргүүн ээлжид худалдах энгийн хувьцааны зах зээлийн үнийг нийтэд санал болгож буй зах зээлийн нэгж үнэтэй тэнцүү байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ



“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ /ТӨСӨЛ/

2025 оны 04 сарын 25

№

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 2025 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт орсон төслийг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасны дагуу баталсугай.
2. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг тогтоолын бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ